



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/268

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 78 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Рэнчинлхүмбэ сумаас ногоон тэжээл тээвэрлэн ирсэн зардалд 1.200.000 (Нэг сая хоёр зуун мянган) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх 1.200.000 (Нэг сая хоёр зуун мянган) төгрөгийг аймгийн Мал хамгаалах сангийн төсвөөс гаргаж, холбогдох журамд нийцүүлэн тээвэрлэн ирсэн жолоочид олгохыг Мал хамгаалах сангийн нягтлан бодогч (Я.Баянжаргал)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ц.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД